



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2022 оны 5 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар
хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

1. "БООБШ" ХХК-ийн нэхэмжлэлтэй, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Д.Лхамжав, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа нарыг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1-д заасан хэргийн оролцогчийн эрх, 26.3-т заасан нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах эрхийг олгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ